



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/61

Шивээговь сум

Сумын Засаг даргын "Жуух бичиг"-ээр
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/15 дугаар захирамжаар батлагдсан "Сумын Засаг даргаас олгох шагналын журам"-ын 2.1.3, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сум, орон нутагтаа идэвх санаачлагатай ажиллаж, эрүүл мэндийн салбарт оруулсан хувь нэмрийг нь үнэлж Эрүүл мэндийн төвийн сувилагч Чүлтэмсүрэнгийн Цэцэгмаа, Алтангэрэлийн Даваасүрэн нарыг Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2.Шагналд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Шагналд зарцуулагдах 60,000 (жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын 2023 оны 05-р сарын 11-ны өдрийн 1/1 дугаар захирамжийн хавсралт

“ЖУУХ БИЧИГ” ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023.05.11

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Засаг даргын “Жуух бичиг”				
1	Мөнгөн шагнал	2	30,000	60,000
Нийт				60,000